



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/101

Улаанбаатар хот

Албан даалгавар,
зөвлөмжийг хэрэгжүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/04 тоот албан даалгавар, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2017 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 3/1010 тоотоор ирүүлсэн зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, идэвхижил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр гарсан тушаал шийдвэр, оношлогоо эмчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулах, иргэдэд хүүхдийн байгууллагад чиглэсэн сургалт зохион байгуулахыг Хүүхдийн ерөнхий зохицуулагч/ Б.Онон/-д даалгасугай.

2. Шаардлагатай үед ор зохицуулах, нэмэлт ор дэлгэж нэмэлтээр ажиллах хүний нөөцийн судалгааг гаргаж бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга / Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.

3.Үйлчлүүлэгчдийн амны хаалт болон гар халдваргүйтгэх нөхцөл бололцоог бүрдүүлж ажиллахыг Төв салбарын эрхлэгч / Д.Молор-эрдэнэ/, Яармаг салбарын эрхлэгч /Г.Оюунцэцэг/ нарт үүрэг болгосугай.

4. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай байгаа эм/ вирусын эсрэг эм/ оношлуур урвалж , эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж ажиллахыг Эмийн сангийн эрхлэгч /Ц.Оюунцэцэг/-д даалгасугай.

5. Томуу томуу төст өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээ, бэлэн байдлын чиглэлээр дэмжлэгт хяналт тандалтыг Өрхийн эрүүл мэндийн төв, хүүхдийн байгууллага, тасаг нэгжүүдэд хийж мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга / Б.Лувсанням/ -д даалгасугай.

6. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт ДААЛГАХ нь:

6.1. Хүн амын дунд Томуу томуу төст өвчин нэмэгдэж амбулаторийн үзлэгийн ачаалал ихсэх үед эмч мэргэжилтнүүдийг дайчлах, уртасгасан цагаар ажиллуулах хуваарь судалгааг гаргаж батлан тусламж үйлчилгээнд шаардлагатай, эм

170 70 0928

эмнэлгийн багаж хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгал халдваргүйтгэлийн бодисын бэлэн байдлыг хангаж ажиллах

6.2. Томуу томуу төст өвчинтэй тэмцэх сэргийлэх талаар гарсан Эрүүл мэндийн сайдын 2010 оны 362, 2014 оны 358, 2017 оны А/346 тоот тушаал, 2017 оны 04 тоот албан даалгавар бусад холбогдох заавар зөвлөмжүүдийг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүддээ судлуулан дотоодын сургалтыг хийж хэрэгжүүлэн ажиллах

6.3. Томуу томуу төст өвчнөөр хүндрэх эрсдэлтэй 0-5 хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, амьсгалын замын архаг өвчтэй хүмүүс, өндөр настангуудын эргэлтийг тогтмол хуваарийн дагуу хийж, зөвөлгөө өгөх ажлыг эрчимжүүлэн ажиллах

6.4. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч ажилтнууд, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настангууд болон эрсдэлт бүлгийн хүн амыг улирлын томуугийн эсрэг вакцины дархлаажуулалтанд бүрэн хамруулж, эмч эмнэлгийн ажилчдыг нэг удаагийн маск, гар ариутгагчаар ханган ажиллах

6.5. Томуу томуу төст өвчнөөс сэргийлэх талаар үйлчлэх хүрээнийхээ хүн амын дунд болон харьяа сургууль цэцэрлэгүүдийн хүүхэд, багш ажилчид, эцэг эх асран хамгаалагч нарт зориулсан мэдээлэл, сургалт сурталчилгааг эрчимжүүлэн ажиллах

6.6. Томуу томуу төст өвчинтэй тэмцэх, сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 7 хоног тутам ХҮЭМТөвийн томуу томуу төст өвчнөөс сэргийлэх ажлын хэсгийн нарийн бичиг тархвар судлаач эмч /Д. Ичинхорлоо/-д ирүүлж байх

7. Томуу томуу төст өвчин, амьсгалын замын хурц халдварт өвчнүүдээс сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, урьдчилан сэргийлэх гарын авлага, МСС-ын ажлыг өргөжүүлэн ажиллахыг Мэдээлэл сургалт сурталчилгааны арга зүйч /Б.Эрдэнэсүвд/-д үүрэг болгосугай

8. Томуу томуу төст өвчинтэй тэмцэх, сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг нэгтгэж холбогдох газруудад хүргүүлэхийг /тархвар судлаач эмч /Д. Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

9. Томуу томуу төст өвчний дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэмэлтээр болон илүү цагаар ажиллах эмч, ажилчдын илүү цагийн хөлсийг байгууллагын зохих зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Д.Хишигсүрэн/-д зөвшөөрсүгэй.

10. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ЭТҮЧА-ны дарга /Б.Оюумаа/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БОДЬЦЭЦЭГ